

БАЯНОЛ ДҮҮРГИЙН 114 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Нэг. Байгууллагын түүх

Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг нь 1987 оны 7 сард Октябрийн районы 114 дүгээр цэцэрлэг, яслийн комбинат нэртэйгээр “Хүүхдийн төлөө фонд”-ын хөрөнгөөр байгуулагдаж 12 бүлэг 41 багш, ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

1993 оноос 12 бүлэг, 41 багш, ажилчидтай, 260 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай ажиллаж байна.

Тус цэцэрлэг нь 15 багштай үүнээс магистр багш-2, тэргүүлэх зэрэгтэй багш-2, заах аргач зэрэгтэй багш-8, сурган хүмүүжүүлэх коллеж төгссөн баклавар зэрэгтэй багш-8 тус тус ажиллаж байна.

Энэ хугацаанд бэлтгэл бүлгийг 38 удаа төгсгөж 2708 хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд амжилттай бэлтгэж өгсөн байна.

Тус цэцэрлэгийн хамт олон Ардын боловсролын тэргүүний ажилтан-8, БСШУЯ-ы жуух бичигтэн-6, Заах аргач цол тэмдэгтэй багш ажилтан-10, ахлах багш цол тэмдэгтэн-12, багшийн алдар медальт багш-11, худалдааны тэргүүний ажилтан -1, эрүүл мэндийн тэргүүний ажилтан-1, Улаан загалмайн тэргүүний ажилтан-1, тэргүүний залуу алтан медальт-2 зэрэг үе үеийн шилдэг багш ажилчидтай.

Мөн тус хамт олон нь 20 гаруй жилийн хугацаанд олон сайхан амжилт гаргаж байснаас 1993,1994,1995 онуудад хүүхэлдэйн урлагийн наадмаар дүүргээс шалгарч хотын хэмжээнд 3 дугаар байрт орж байжээ. Мөн онуудад цэнгээнт бүжгээр дүүрэг, хотын тэмцээн наадамд амжилттай оролцож 1992 онд хотын 2 дугаар байр, 2000 онд цаатан бүжгээр алтан медаль авч Ардын хувьсгалын 80 жилийн ойн концертод орох эрхээр шангуулж байжээ. 2004 онд “Уран жиргээ” уран уншлагын тэмцээнд ахлах бүлгийн Дэлгэрсувд дүүрэгт 3 дугаар байранд шалгарч, 2005, 2007 оны бяцхан тод авьяастан тэмцээнд 5 хүүхэд оролцож тусгай байр, мөн “Үлгэрийн баатрууд амилсан нь”, бяцхан мисс улсын уралдаан, “Ногоон гэрэл цагаан шугам”, зургийн уралдаан зэрэг уралдаан тэмцээн наадмуудад хүмүүжигч хүүхдүүдээ амжилттай бэлтгэж өндөр амжилт гарган оролцож иржээ.

2004-2005 онд тус цэцэрлэг нь “Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-д нийцсэн байгууллага болсон байна.

Багш ажилчдын хувьд өөрсдийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх, хөгжүүлэх тал дээр идэвхи санаачлагатай байж ур чадвараар дүүрэг, хот, улсын хэмжээний уралдаан тэмцээнүүдэд байнга оролцож дээгүүр байр эзэлж ирдэг байна.

Жишээлбэл: “Ур чадварын аварга”-аар АБТАжилтан багш Ц.Оюун, Д.Ганцэцэг, “Хичээл нь нээлттэй” багшаар АБТА багш Л.Доржханд, Д.Лхагва-Очир, Д.Нямсүрэн нар амжилттай оролцож дүүрэгтээ 2 дугаар байр эзэлсэн байна. 2006-2007 оны хичээлийн жилд эрүүл мэндийг дэмжигч байгууллага болж 2007 оны “Дүүргийн тэргүүний цэцэрлэг”-ээр шалгарсан байна.

2011-2012 оны хичээлийн жилд манай цэцэрлэг хүүхдийн унаган авъяасыг хөгжүүлснээр улсын хэмжээнд зохиогддог “Замын хөдөлгөөний цагаан толгой” уралдаанд 12 хүүхэд амжилттай оролцон 3-р байр эзэлж хүрэл медаль, “Монгол гоёл - Монгол гоёл” тэмцээнд 12 бүлгийн нийт 35 хүүхэд оролцож Баянгол дүүрэгт 2-р байр эзэлж мөнгөн мөнгөн медаль, үнэ бүхий зүйл, “Бяцхан ханхүү” тэмцээнд Бэлтгэл “А” бүлгийн Ц. Тэнгис мөнгөн медаль, Хүүхэд залуу үе хөгжлийн төвийн “Авъяас” мөнгөн медалиар 10 хүүхэд тус тус шагнагдлаа.

Цэцэрлэгийн эрхлэгчээр :

1987- 1991 оны хооронд Ё.Оюуннэмэх

1992- 2002 оны хооронд Х.Жаваа

2002 оноос одоог хүртэл Г.Оюунсүрэн нар ажиллаж байна.

1987-1992 оны хооронд Октябрийн районы 114 дүгээр цэцэрлэг яслийн комбинат

1993-1996 оны хооронд БГД-ийн 114 дүгээр ясли, цэцэрлэг

1997 оноос БГД-ийн 114 дүгээр цэцэрлэг нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хоёр. Хөмрөгийн түүх

Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг нь 1987 онд байгуулагдсан цагаасаа байгууллагын үйл ажиллагааны явцад үүсэн гарсан баримтыг байгууллага дээрээ хадгалж байсан бөгөөд архивын тусгай өрөө, тасалгаагүй байв.

2007 онд архивын ажилтан Д.Дашдолзод 1987-2007 оны баримтуудад ЭШТБ-ын ажил хийж цэгцэлсэн бөгөөд цэцэрлэгийн эрхлэгчийн тушаал, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ерөнхий менежийн үр дүнгийн гэрээ, санхүүгийн тайлан тэнцэл гэсэн бүрдэлтэй байнга хадгалах 28 хадгаламжийн нэгж, түр хадгалах 75 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 17 хадгаламжийн нэгж баримтыг байгууллагын архивт хүлээлгэн өгсөн байна. 1987-1997 оны 13 хэргийн нийт 52,5 кг баримтыг устгахаар акт үйлдэн устгалд оруулсан байна.

Нярав Г.Цэрэнханд миний бие нь 2011 онд тус цэцэрлэгт томилогдон ирээд архивын ажлыг давхар хариуцан ажиллав. Энэ хугацаанд 2010-2012 оны

баримтуудыг ажилтнуудас хүлээн авч эмхлэн цэгцэлж, нийслэлийн архивын газарт архивын баримтын тоон тайлан мэдээг цаг тухай бүрт өгсөөр ирсэн.

Архивын баримтыг хүлээн авах үед баримтын хувьд бүрдэл дутуу, албан хэрэг хөтлөлт, боловсруулалтад анхаарах шаардлагатай байв.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан, сургалтын төлөвлөгөө, багш, ажилчдын төлөвлөгөө, тайлан, хурлын тэмдэглэл зэрэг нь дутуу, байгаа баримтууд нь он сар өдрийг тодорхойлох боломжгүй, баримт бичгийн стандартын шаардлага хангаагүйн улмаас үдэж хавтаслахад хүндрэлтэй байв.

1987-2012 оны хоорондох архивын баримтыг эмхлэн цэгцэлж төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр шилжүүлэн өгөх төлөвлөгөөний дагуу нийслэлийн архивын газрын арга зүйч Н.Хишигжаргалаас заавар, зөвлөгөө авч, мөн архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад удаа дараа сууж зааврын дагуу дээрх баримтуудыг эмхлэн цэгцэлсэн.

Баянгол дүүргийн 120 дугаар цэцэрлэгтэй зэргэлдээ оршдог бөгөөд энэ 2 цэцэрлэгийн дунд нэг нятлан ажилладаг байсны улмаас санхүүгийн баримтууд тухайлбал 1992-1995 оны ажилтны цалин хөлсний баримтыг нийлүүлэн нэг дор үдсэн байсан бөгөөд эдгээр цалингийн картуудыг 120 дугаар цэцэрлэгийн эрхлэгч шилжүүлж өгөхгүй гэсэн учир дээрх онуудын цалин нь тасран одоо 120 дугаар цэцэрлэгт хадгалагдаж байгаа болно.

Үүний үр дүнд 1987-2012 оны байнга хадгалах 126 хадгаламжийн нэгж, түр хадгалах 2001-2012 оны 125 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1987-2012 оны 51 хадгаламжийн нэгж баримтыг цэгцэлж данс бүртгэл үйлдлээ. Мөн 1999-2000 оны 14 хэргийн 87 хадгаламжийн нэгж баримтыг устгахаар устгах хэргийн акт үйлдээд байна. Эрхлэгчийн тушаалыг байнга хадгалах, 70 жил хадгалах гэж ялгасан бөгөөд 1987-2012 оны байнга хадгалах 26 нэгж, 70 жил хадгалах 2008-2012 оны 5 нэгж нийт 31 хадгаламжийн нэгж эрхлэгчийн тушаалд цахим хувь үйлдэн цахим баримтаар хөмрөг үүсгэх ажил хийгдэж байна.